



ШҮҮХИЙН СУРГАЛТ,  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ХЯНАЛТЫН ШАТНЫ  
ШҮҮХИЙН ЧИГ ҮҮРЭГ,  
ЭРХ ХЭМЖЭЭ**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2022/07/20

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ  
2022.09.30

## ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
УДИРТГАЛ.....	3
ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	9
ГУРАВ. ТООН МЭДЭЭЛЭЛ.....	16
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ .....	40
ЭХ СУРВАЛЖ.....	42

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>БНТУ</b>	Бүгд Найрамдах Турк Улс
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>ИХ</b>	Иргэний хууль
<b>ИХШХШтХ</b>	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
<b>МУШтХ</b>	Монгол Улсын шүүхийн тухай хууль
<b>ОХУ</b>	Оросын Холбооны Улс
<b>ХБНГУ</b>	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
<b>УДШ</b>	Улсын дээд шүүх
<b>ШЕЗ</b>	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
<b>ШССМХ</b>	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

## УДИРТГАЛ

### Судлах зүйл

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн түүхэн хөгжил, хуульд тусгагдаж байсан хяналтын гомдол гаргах үндэслэл, хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээний зохицуулалтын талаар түүхчилсэн судалгаа хийхийн зэрэгцээ гадаад улсын хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийн талаар судлах, судалгааны ажлын хүрээнд сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас шийдвэрлэсэн нийт маргааны тоон мэдээлэл болон тэдгээр талаар дэлгэрэнгүй мэдээллийг судалж илрүүлэхэд оршино.

### Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр болох “Шүүхэд хандах эрх: Хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд мэдээлэл өгөхөд чиглэгдсэн болно.

### Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсад батлагдан хэрэгжиж байсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж, гадаадын зарим улсыг сонгон авч түүхчилсэн болон харьцуулсан судалгаа хийв. Мөн УДШ-ийн Практик судалгааны хэлтсээс ШССМХ-д ирүүлсэн статистик тоон мэдээ, ШЕЗ-өөс гаргасан “Монгол Улсын шүүхийн тайлан”-д судалгаа хийлээ.

### Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох түүхчлэн судлах, харьцуулан судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

### Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн түүхэн хөгжил, Харьцуулсан судалгаа, Тоон мэдээлэл, Дүгнэлт гэсэн дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ.

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ИХШХШТХ-ИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Монгол Улсын ИХШХШТХ-ийн хяналтын журмаар гомдол гаргахтай холбоотой зохицуулалт, Улсын дээд шүүхийн эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг 1952 оны Иргэний байцаан шийтгэх хууль, 1967 оны Иргэний байцаан шийтгэх хууль, 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2012 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд тус тус судаллаа. Үүнийг дэлгэрүүлбэл:

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	<p style="text-align: center;"><b>Монгол Улсын шүүхийн тухай хууль</b></p> <p style="text-align: center;"><b>/2012/</b></p>	<p><b>15 дугаар зүйл.Улсын дээд шүүх</b>                      15.1.Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.                      15.2.Улсын дээд шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх иргэн, эрүү, захиргааны хэргийн дагнасан танхимтай байна.</p> <p><b>16 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүн</b>                      16.1.Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ.                      16.2.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 15.2-т заасан танхимын аль нэгд харьяалагдах бөгөөд түүнийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх өөр танхимын шүүн таслах ажиллагаанд оролцуулахыг хориглоно.</p> <p><b>17 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн бүрэн эрх</b>  <b>17.1.Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн иргэн, эрүү, захиргааны хэргийн магадлалтай холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг талуудын гомдол, Улсын ерөнхий прокурор, эсхүл түүний эрх олгосон прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.</b>                      17.2.Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.                      17.3.Улсын дээд шүүх энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:                      17.3.1.Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;                      17.3.2.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;                      17.3.3. энэ хуулийн 15.2-т заасан танхимыг байгуулах;                      17.3.4.хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;                      17.3.5.энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;                      17.3.6.энэ хуулийн 7.4, 17.3.4-т заасан болон бусад хуульд заасан асуудлыг хуралдаанаар шийдвэрлэх;                      17.3.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах тухай санал гаргах;                      17.3.8.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
2.	<p style="text-align: center;"><b>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/</b></p> <p style="text-align: center;"><b>/2021/</b></p>	<p><b>25 дугаар зүйл.Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх</b>                      25.1.Улсын дээд шүүх Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.                      25.2.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэн, захиргааны хэргийн зэрэг дагнасан танхимтай байна.                      25.3.Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөн шүүгчээс бүрдэнэ.  <b>25.4.Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.</b></p>

		<p>25.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч энэ хуулийн 25.2-т заасан танхимын аль нэгд харьяалагдана.</p> <p>25.6.Улсын дээд шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.</p> <p><b>25.7.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</b></p> <p>25.7.1.хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;</p> <p>25.7.2.энэ хуулийн 25.7.1-д заасан болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх;</p> <p>25.7.3.хуульд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;</p> <p>25.7.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;</p> <p><b>25.7.5.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:</b></p> <p><b>25.7.5.а.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;</b></p> <p><b>25.7.5.б.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;</b></p> <p><b>25.7.5.в.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.</b></p> <p>25.8.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>25.8.1.хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүхэд хэрэг, маргааны төрлөөр дагнасан танхим байгуулах, бүрэлдэхүүнийг батлах;</p> <p>25.8.2.давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн хэлэлцэж, шийдвэрлэх;</p> <p>25.8.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хууль санаачлагчид уламжлах;</p> <p>25.8.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;</p> <p>25.8.5.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;</p> <p>25.8.6.энэ хуулийн 73.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 6.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;</p> <p>25.8.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах;</p> <p>25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;</p> <p>25.8.9.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
--	--	--

<b>Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, чиг үүргийг хуульчилсан байдал</b>	
<b>Хуулийн нэр</b>	<b>Хуулийн зүйл заалт</b>
1952 оны Иргэний байцаан шийтгэх хууль	<p><b>113 дугаар зүйл.</b> Шүүх Яамны сайд, Улсын прокурор, Дээд Шүүхийн дарга нар нь тус улсын ямар ч шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэртэй ямар ч хэргийг хянах журмаар шаардан авч хянах эрхтэй ба хянах явдлаа дуусах хүртэл хугацаанд уг шийдвэрийг гүйцэтгэх явдлыг зогсоох эрхтэй болно.</p> <p><b>118 дугаар зүйл.</b> Энэ хуулийн 114 ба 115 дугаар зүйлд заасан хэргүүдийг хянах журмаар татах явдлыг хугацаагаар үл хязгаарлана.</p>

<p>1967 оны Иргэний байцаан шийтгэх хууль</p>	<p style="text-align: center;"><b>Гучин дөрөвдүгээр бүлэг</b> <b>ШИЙДВЭР, МАГАДЛАЛ БА ТОГТООЛЫГ ХЯНАЛТЫН ЖУРМААР ДАХИН ХЯНАХ</b></p> <p style="text-align: center;"><b>241-р зүйл. Хяналтын журмаар бичсэн эсэргүүцлийг хянан хэлэлцэх</b></p> <p>Районы (хотын) шүүх буюу аймгийн нүүдлийн шүүхийн шийдвэр, магадлалд хяналтын журмаар бичсэн эсэргүүцлийг аймаг хотын шүүхийн шүүх коллеги хянан хэлэлцэнэ.</p> <p>Аймаг, хотын шүүхийн шийдвэр, магадлалд хяналтын журмаар бичсэн эсэргүүцлийг БНМАУ-ын Дээд Шүүхийг иргэний хэрэг эрхэлсэн коллеги хянан хэлэлцэнэ.</p> <p>БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурал БНМАУ-ын бүх шатны шүүхийн шийдвэр, магадлалд бичсэн эсэргүүцлийг хянан хэлэлцэх эрхтэй.</p> <p style="text-align: center;"><b>242-р зүйл. Хэрэг шаардан авах эрх</b></p> <p>Энэ хуулийн 240-р зүйлд заагдсан албан тушаалтан, мөн районы ба хэсгийн прокурорууд нь хяналтын журмаар эсэргүүцэл бичих үндэс байгаа эсэхийг шийдвэрлэхийн тулд иргэний хэргийг зохих шатны шүүхүүдээс шаардан авах эрхтэй.</p> <p>Хэрэг шаардан авсан этгээд шүүхийн шийдвэр, магадлал буюу тогтоолд эсэргүүцэл бичих шаардлагатай гэж үзсэн бөгөөд хэрэв эсэргүүцэл бичих эрхгүй бол өөрийн дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хяналтын журмаар эсэргүүцэл бичүүлэхээр саналаа оруулна.</p> <p>Хэрэв эсэргүүцэл бичих үндэс байхгүй бол энэ тухай хүсэлт гаргагч этгээдэд мэдэгдэж, хэргийг зохих шүүхэд буцаана.</p> <p style="text-align: center;"><b>243-р зүйл. Шийдвэр, магадлал, тогтоолын гүйцэтгэлийг түдгэлзүүлэх</b></p> <p>Эсэргүүцэл бичих эрх бүхий албан тушаалтан хяналтын журмаар хэрэг хянаж байгаа шүүхийн шүүн таслах ажиллагаа явагдаж дуустал уг шийдвэр, магадлал, тогтоолыг биелүүлэх явдлыг түдгэлзүүлж болно.</p> <p style="text-align: center;"><b>248-р зүйл. Шүүхийн бүрэн эрх</b></p> <p>Хяналтын журмаар хэрэг хянан хэлэлцсэн шүүхээс гаргах шийдвэр:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, эсэргүүцлийг хангахгүй орхих;</li> <li>2) Шийдвэр, магадлал, тогтоолыг бүрэн буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцэхээр буцаах, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг авч хэлэлцэхгүй орхих</li> <li>3) Хэрэв эрхийн хэм хэмжээг хэрэглэхдээ алдаа гаргасан боловч хэргийн байдлыг бүрэн, зөв тогтоосон ба нотлох баримтыг цуглуулах буюу түүнд нэмэлт шалгалт шаардлагагүй бол шийдвэр, магадлал, тогтоолыг өөрчлөх.</li> </ol> <p style="text-align: center;"><b>249-р зүйл. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгох үндэслэл</b></p> <p>Хяналтын журмаар бичсэн эсэргүүцлээр хэрэг хянаж байгаа шүүх энэ хуулийн 226, 227-р зүйлд заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p> <p>Шүүхийн шийдвэр, магадлалыг дээд шатны шүүх үндэсгүйгээр хүчингүй болгосон буюу эсхүл хэрэг хянан хэлэлцэхдээ дээд шатны шүүх хууль зөрчсөн явдал нь шийдвэр, магадлалыг зөв гаргахад муугаар нөлөөлсөн буюу нөлөөлж болох байвал дээд шатны шүүхийн магадлалыг хяналтын журмаар хүчингүй болгоно.</p> <p style="text-align: center;"><b>250-р зүйл. Шүүхийн магадлал тогтоол</b></p> <p>Хяналтын журмаар хэрэг хянан хэлэлцэж гаргасан шүүхийн магадлал, тогтоолыг давж заалдаж болохгүй бөгөөд тэр нь гарсан өдрөөсөө эхлэн хуулийн хүчин төгөлдөр болно.</p> <p>Хяналтын журмаар хэрэг хянан хэлэлцсэн шүүхийн магадлал, тогтоолын агуулга, гаргах холбогдол нь энэ хуулийн 228-232 зүйлд заасан журмаар тодорхойлогдоно.</p>
<p>1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль</p>	<p style="text-align: center;"><b>178 дугаар зүйл. Эсэргүүцлийг хянан хэлэлцэх</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бичсэн эсэргүүцлийг тухайн аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар хянан хэлэлцэнэ.</li> <li>2. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт Улсын дээд шүүхийн шүүгчийн бичсэн эсэргүүцлийг зохих аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар; давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан</li> </ol>

	<p>шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорын бичсэн эсэргүүцлийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан хэлэлцэнэ.</p> <p><b>179 дүгээр зүйл. Шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх</b></p> <p>Хэргийг хяналтын шүүх хуралдаанаар шийдвэрлэтэл анхан шатны буюу давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэгдээгүй хэсгийн биелэлтийг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч захирамжаар түдгэлзүүлж болно.</p> <p><b>180 дугаар зүйл. Хэрэг татан авах</b></p> <p>1. Аймаг, нийслэлийн болон Улсын дээд шүүхийн шүүгч ямар ч хэргийг доод шатны шүүхээс татан авах эрхтэй.</p> <p>2. Улсын ерөнхий прокурор нь доод шатны прокурорын санал бичсэн хэргийг татан авах эрхтэй.</p> <p><b>190 дүгээр зүйл. Хүсэлтийг шийдвэрлэх</b></p> <p>1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлтийг энэ хуулийн 170, 184 дүгээр зүйлд заасан журмаар шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>2. Шүүх хуралдаанд хүсэлт гаргагч оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх ба түүний ирээгүй явдал хүсэлтийг хэлэлцэхэд саад болохгүй.</p> <p>3. Шүүх хүсэлтийг хянан хэлэлцээд түүнийг хангах буюу эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана.</p> <p>4. Шүүх хүсэлтийг хангах тухай тогтоол гаргавал уг тогтоолоор урьд гаргасан шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар хэлэлцүүлэхээр зохих шүүхэд шилжүүлнэ.</p>
<p>2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль</p>	<p><b>173 дугаар зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах</b></p> <p>173.1. Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авах бөгөөд энэ хуулийн 163.1-д заасан ажиллагааг гүйцэтгэнэ. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй.</p> <p>173.2. Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.</p> <p>173.3. Хяналтын журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1, 57.4-т заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.</p> <p>173.4. Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.</p> <p>173.5. Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.</p> <p>173.6. Энэ хуулийн 173.5-д заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана.</p> <p>173.7. Энэ хуулийн 173.5, 173.6-д заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.</p> <p>173.8. Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.</p>
<b>Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл</b>	
<p><b>Хуулийн нэр</b></p>	<p><b>Хуулийн зүйл заалт</b></p>
<p>1952 оны Иргэний байцаан шийтгэх хууль</p>	<p><b>115 дугаар зүйл.</b> Шаардан татсан хэргийн шийдвэрт нь хуулийг гажуудуулсан буюу шинээр ямар нэг байдал илрэн гарвал, аймаг хотын прокурор нь уг хэрэгт эсэргүүцэл бичүүлэхээр улсын прокурорт явуулна.</p> <p>Тайлбарлах нь:</p> <p>Шинээр илрэх байдал гэдэг нь</p> <p>а) Шүүхээс гаргасан шийдвэр нь хуурамч буюу буруу баримт бичгийг үндэслэн хянаж шийдвэрлэсэн болох нь хожим шүүхийн тогтоолоор буюу зохих байгууллагаас хүчингүй болгосон нь илэрвэл.</p>

	<p>б) Шийдвэр нь гэрчийн этгээдийн худал мэдүүлгийг үндэслэсэн болох нь шүүхийн тогтоолоор илэрвэл. 117 дугаар зүйл. Дээд шүүхийн иргэний коллегийос хянаж үзэж гаргасан шийдвэр ба магадлалыг Дээд Шүүхийн дарга, Шүүх Яамны сайд, Улсын прокурор нараас хянах журмаар Дээд Шүүхийн бүгд хуралд эсэргүүцэл бичиж болно.</p>
1967 оны Иргэний байцаан шийтгэх хууль	<p><b>204-р зүйл. Хяналтын журмаар эсэргүүцэл бичих эрх</b> БНМАУ-ын Дээд шүүхийн дарга, БНМАУ-ын прокурор нь БНМАУ-ын аль ч шүүхийн шийдвэр, магадлал, шүүгчдийн тогтоолд хяналтын журмаар эсэргүүцэл бичих эрхтэй. БНМАУ-ын Дээд шүүхийн даргын оролцогчид, БНМАУ-ын прокурорын оролцогчид нь аймаг, хот, районы (хотын) шүүх ба аймгийн нүүдлийн шүүхийн шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолд хяналтын журмаар эсэргүүцэл бичих эрхтэй. Аймаг, хотын шүүхийн дарга, аймаг, хотын прокурор нь районы ба аймгийн нүүдлийн шүүхийн шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолд хяналтын журмаар эсэргүүцэл бичих эрхтэй.</p> <p><b>239-р зүйл. Хяналтын журмаар эсэргүүцэл бичиж болох шийдвэр</b> БНМАУ-ын бүх шатны шүүхийн шийдвэр, магадлал ба шүүгчийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор зохих эрх бүхий албан тушаалтан уг шийдвэр, магадлал ба тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хяналтын журмаар эсэргүүцэл бичиж болно.</p>
1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	<p><b>177 дугаар зүйл.Хяналтын журмаар эсэргүүцэл бичих</b> 1.Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт; Улсын дээд шүүхийн шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй хүчин төгөлдөр болсон шийдвэр, давж заалдах хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй. 2.Улсын ерөнхий прокурор давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй. 3.Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч бичсэн эсэргүүцлээ хяналтын журмаар хянан хэлэлцэхээс өмнө буцаан авч болно.</p>
2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	<p><b>172 дугаар зүйл.Хяналтын журмаар гомдол гаргах</b> 172.1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 167 дугаар зүйлд заасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй. 172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана: 172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн; 172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн; 172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.</p>

Дээрхээс хуулийн зохицуулалтаас үзвэл, Улсын дээд шүүх нь шүүх эрх мэдлийн дээд байгууллага төдийгүй хяналтын журмаар гаргасан гомдлыг хуульд заасан үндэслэлээр хүлээн авч хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага байна.

2012 оны МУШТХ-д хяналтын журмаар гомдол гаргах ерөнхий үндэслэлийг хуульчлаагүй<sup>1</sup> байсан бол 2021 оны хуулиар хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг

<sup>1</sup> ИХШХШТХ-ийн 172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсгийн “Хяналтын журмаар дараахь үндэслэлээр гомдол гаргана” гэсэн зохицуулалтад “172.2.1.шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, 172.2.2.шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” гэсэн үндэслэлээр хяналтын гомдол гаргахаар байсан бол 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

“Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх” гэсэн зохицуулалтын хүрээнд хуулийн 25 дугаар зүйлд хуульчилж, салбар эрх зүйн процессын хууль бүрд өөрчлөлт оруулан хяналтын журмаар гомдол гаргахтай холбоотой зохицуулалтын өөрчлөлтийг нэмсэн байна.

БНМАУ-ын 1952, 1967 оны Иргэний байцаан шийтгэх хуульд “Шүүх Яамны сайд, Улсын прокурор, Дээд Шүүхийн дарга нар аль ч шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэртэй бүхий л хэргийг хянах журмаар шаардан авч хянах эрхтэй” хэмээн хуульчилж байсан боловч хэргийн оролцогчид хяналтын гомдол гаргах эрхгүй байсан. Харин 1994 оны ИХШХШТХ-иар УДШ-ийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй болсон бөгөөд зөвхөн УДШ-ийн магадлалд “хэргийн оролцогчийн гомдлоор буюу хуульд заасан этгээд өөрийн санаачилгаар” хяналтын журмаар эсэргүүцэл бичихээр хуульчилсан нь өмнөх хуулиудаас хэргийн оролцогчийн гомдлоор хяналтын эсэргүүцэл бичиж байснаараа онцлог зохицуулалт байжээ. 2002 оны ИХШХШТХ-иар хяналтын гомдлыг зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмнгөөлөгч нар гаргадаг болсноороо хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй этгээдийн хүрээ өргөжин тэлсэн ач холбогдолтой болжээ гэж үзсэн болно.

## ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгааны хүрээнд БНХАУ, БНСУ, БНТУ, ОХУ, ХБНГУ-ыг сонгон авч тухайн улсын шүүхийн систем, дээд шүүхийн эрх хэмжээ, чиг үүргийн талаар болон зарим улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийн талаар судаллаа.

### 1. БНХАУ

Ардын Дээд Шүүх нь тус улсын шүүх эрх мэдлийн дээд байгууллага бөгөөд энэхүү эрх мэдлээ бие даан хэрэгжүүлдэг төдийгүй Хятадын Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон Байнгын хороонд ажлаа тайлагнадаг. Ардын дээд шүүх нь Мужийн Ардын Шүүх болон бүх шатны ардын тусгай шүүхийн практикт хяналт тавьдаг дээд байгууллага юм. Ардын дээд шүүхийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, шүүх хуралдааны хорооны гишүүдийг томилох, огцруулах эрх нь Хятадын Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хуралд байдаг. БНХАУ-ын Ардын дээд шүүхийн эрх хэмжээ, чиг үүргийг доорх хүснэгтээр харуулав<sup>2</sup>:

<b>Ардын дээд шүүхийн эрх хэмжээ, чиг үүрэг</b>
1. Дараах хэргийг хянан шийдвэрлэх: Хууль, журмын дагуу Ардын дээд шүүхэд шилжүүлсэн болон Ардын дээд шүүх өөрийн харьяаллын дагуу гэж үзсэн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх; Ардын Дээд шатны шүүх (higher court) болон онцгой шүүхийн шийдвэр, магадлалд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан бол; Шүүхийн хяналтын журмын дагуу Ардын Дээд Прокурорын гаргасан шүүхийн шийдвэрийг давж заалдах тохиолдолд.
2. Цаазаар авах ял оногдуулах. Хүний амь насыг хөнөөсөн, эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн, дээрэм тонуул, тэсэрч дэлбэрэх бодис ашиглан устгасан болон олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журамд ноцтой аюул учруулсан, хор хөнөөл учруулсан бусад хэрэгт холбогдсон гэмт хэрэгтнүүдэд цаазаар авах ял оногдуулах эрхийг Ардын дээд шүүх шаардлагатай үед хэрэгжүүлж болно.
3. Мужийн Ардын Шүүх болон Тусгай Ардын Шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих.
4. Хуулийн дагуу хэрэгжиж эхэлсэн Мужийн Ардын Шүүхийн шийдвэр, магадлалын алдааг илрүүлэх, байцаалт явуулах, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах тухай шийдвэрлэх.

хуулийн 3 дугаар зүйлд зааснаар МУШТХ /2021/-ийн 25.7.5 дахь заалтад заасан үндэслэлээр хяналтын гомдол гаргахаар болж өөрчлөгдсөн байна.

<sup>2</sup> БНХАУ-ын Ардын дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, [https://english.court.gov.cn/2015-07/16/c\\_769578.htm](https://english.court.gov.cn/2015-07/16/c_769578.htm), (Сүүлд үзсэн: 2022.09.29).

5. Эрүүгийн хуульд тусгайлан заагаагүй гэмт хэргийн шийтгэх тогтоолыг батлах.
6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль хэрэглээний талаар тодорхой тайлбар өгөх.

Тус улсын Үндсэн хууль болон Иргэний процессын хуульд заасан хяналтын гомдол гаргахтай холбоотой зохицуулалтыг харуулбал:

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
3.	<b>БНХАУ-ын Үндсэн хууль<sup>3</sup></b>	<p>128 дугаар зүйл. БНХАУ-ын Ардын шүүх бол төрийн шүүх эрх мэдлийн байгууллага мөн.</p> <p>129 дүгээр зүйл. БНХАУ-ын шүүх эрх мэдэл нь Ардын дээд шүүх, Мужийн ардын шүүх, цэргийн шүүх болон бусад төрөлжсөн ардын шүүхүүдээс бүрдэнэ. Ардын шүүхийн зохион байгуулалтыг хуулиар тогтооно.</p> <p>130 дугаар зүйл. Ардын шүүх хуульд заасан онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хэргийг нээлттэй хэлэлцэнэ.</p> <p>131 дүгээр зүйл. Ардын шүүх нь хуулийн заалтын дагуу шүүх эрх мэдлийг бие даан хэрэгжүүлэх бөгөөд засаг захиргааны байгууллага, нийгмийн бүлэг, хувь хүн хөндлөнгөөс оролцохгүй.</p> <p>132 дугаар зүйл. Ардын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн. Ардын дээд шүүх нь мужийн бүх шатны ардын шүүх, дагнасан ардын шүүх, дээд шатны ардын шүүх, доод шатны ардын шүүхийн шүүх хуралдаанд хяналт тавина.</p> <p>133-р зүйл. Ардын дээд шүүх нь Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон Байнгын Хорооны өмнө хариуцлага хүлээнэ. Орон нутгийн бүх шатны ардын шүүх нь тэднийг үүсгэн байгуулсан төрийн эрх мэдлийн байгууллагын өмнө хариуцлага хүлээнэ.</p>
4.	<b>Иргэний процессын хууль</b>	<p>БНХАУ-ын Иргэний процессийн хуулийн<sup>4</sup> 21 дүгээр зүйлд зааснаар Ардын дээд шүүх (最高人民法院) нь дараах хэргийг шийдвэрлэх бүрэн эрхтэй:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улс даяар ихээхэн нөлөө үзүүлсэн хэргүүд ба</li> <li>2. Тус шүүхээр хэлэлцэх ёстой гэж үзсэн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.</li> </ol> <p><b>Ардын дээд шүүхээс анхан шатны журмаар хянан шийдвэрлэж байгаа хэргүүд нь улсын хэмжээнд ихээхэн нөлөөтэй, мөн чанар, нөхцөл байдал нь онц ноцтой байх ёстой.</b> Өөрөөр хэлбэл Ардын дээд шүүх нь улс орон даяар ноцтой нөлөөтэй гэж үзсэн хэргээ аль шатны шүүхийн харьяалалд байхаас үл хамааран хянан шийдвэрлэх эрхтэй. Улс орон даяар ихээхэн нөлөөтэй гэж үзэхэд тухайн хэргийн ноцтой шинж байдал, төвөгтэй нөхцөл байдал болон улс оронд үзүүлэх нөлөөг харгалзан үзнэ.</p> <p>Ардын дээд шүүхээс шийдвэрлэдэг хэргүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улс даяар томоохон эсхүл ээдрээ төвөгтэй захиргааны хэргийг анхан шатны журмаар;</li> <li>2. Улс даяар ноцтой нөлөө үзүүлсэн иргэн, худалдааны хэргүүдийг анхан шатны журмаар;</li> <li>3. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны журмаар шийдвэрлэсэн иргэн, худалдааны хэргүүдийг давж заалдсан хэрэг;</li> <li>4. Захиргаа, иргэн, худалдааны хэргийн шүүхийн шийдвэр, давж заалдах шүүхээс гарсан хүчин төгөлдөр болсон эвлэрүүлэн зуучлах баримт бичгийг дахин хянуулах (再審);</li> <li>5. Гомдол гаргасан эрүүгийн хэргүүд;</li> <li>6. Хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан дахин хянуулах гомдлууд;</li> </ol>

<sup>3</sup> <http://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>, (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<sup>4</sup> <http://www.people.com.cn/zixun/flfgk/item/dwjif/falv/9/9-1-1-01.html>, (Сүүлд үзсэн: 2022.09.29).

		<p>7. Давж заалдах шүүхээс гаргасан торгууль ногдуулсан, цагдан хорих шийдвэрийг үл зөвшөөрөн дахин хянуулахаар гомдол гаргасан хэргүүд;</p> <p>8. Давж заалдах шатны шүүхээс хэрэг шийдвэрлэх хугацааг сунгуулахаар гаргасан хүсэлт, цаазаар авах ял оногдуулах тухай зөвшөөрөл;</p> <p>9. Хонг-конг, Макао, Тайваны иргэн, худалдааны болон эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон хэргүүд;</p> <p>10. Ардын шүүх шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад хэргүүд<sup>5</sup>.</p> <p>Иргэний процессын хуулийн 177 дугаар зүйлд зааснаар Ардын дээд шүүх Мужийн ардын шүүхийн шийдвэр хууль ёсны хүчин төгөлдөр болсон, дээд шатны ардын шүүх алдаа гаргасан нь тогтоогдвол дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.</p>
--	--	--

Тус улсын Ардын дээд шүүхэд хяналтын гомдол гаргах ажиллагаа нь дараах байдлаар явагддаг байна:

1. Өргөдөл гаргана. Улсын дээд шүүхэд давж заалдах гомдол гаргах тохиолдолд тухайн хэргийг шийдвэрлэсэн ардын шүүхэд гаргана. Өргөдлийг эсрэг талын төлөөлөгчийн тоогоор гаргана.
2. Шүүхийн шийдвэрийг гардуулснаас хойш 15 хоногийн дотор дараагийн дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.
3. Давж заалдах гомдлыг хүлээн авсан шүүх тав хоногийн дотор гомдлын хувийг нөгөө талд хүргүүлнэ. Нөгөө тал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хариу тайлбар гаргана. Хариу тайлбарыг хүлээн авснаас хойш шүүх 5 хоногийн дотор өргөдөл гаргагчид хүргүүлнэ. Хариу тайлбар гаргаагүй нь шүүх хуралд нөлөөлөхгүй. Шүүх давж заалдах гомдлыг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор хэргийн бүх материал, нотлох баримтын хамт дээд шатны ардын шүүхэд хүргүүлнэ.<sup>6</sup>

Дээрхээс үзвэл, БНХАУ-ын Ардын дээд шүүхэд хяналтын гомдол гаргах үндэслэлд “улсыг хамарсан онц нөлөө бүхий” гэсэн шаардлага тавигддагаараа төдийгүй тус хэргүүдийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг гэдгээрээ онцлог байна.

## 2. БНСУ

БНСУ-ын хувьд гурван шатны шүүх байдаг ба тэдгээр нь Анхан шатны шүүх буюу Дүүргийн шүүх (үүнд: гэр бүлийн шүүх, захиргааны хэргийн шүүх багтана), дунд шатны шүүх буюу Давж заалдах шатны шүүх, эцсийн шатны шүүх буюу Улсын дээд шүүх юм. Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон 13 шүүгчээс бүрддэг бөгөөд иргэний, эрүүгийн, гэр бүлийн, захиргааны болон цэргийн хэргийн эцсийн бөгөөд дээд шатны шүүх мөн болно. Шүүхийн тогтоол нь хууль тогтоомжийг тайлбарлах стандартыг бүрдүүлдэг, эрх зүйн онол, практикийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг, жишиг тогтоосон шийдвэрүүд байдаг<sup>7</sup> гэж үздэг байна.

БНСУ-ын Улсын дээд шүүх нь хувийн эрх зүйн, захиргааны эрх зүйн, оюуны өмчийн, татварын эрх зүйн, эрүүгийн эрх зүйн гэсэн 5 танхимтай. Улсын дээд шүүхэд маргааныг

<sup>5</sup> <https://zhidao.baidu.com/question/761574133409572564.html>, (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<sup>6</sup> <https://wen.baidu.com/question/2211582769825169748.html>, (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<sup>7</sup> БНСУ-ын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, <https://eng.scourt.go.kr/eng/supreme/about/introduction.jsp>, (Сүүлд үзсэн: 2022.09.29).

хянан шийдвэрлэх журмын тухай хуулиар<sup>8</sup> хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг хуульчилж өгсөн бол Иргэний процессын тухай хуулиар<sup>9</sup> процессын эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан.

Дээрх хуулиудад тусгагдсан Улсын дээд шүүхийн эрх хэмжээ, чиг үүргийн талаар доорх байдлаар харуулав:

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	Иргэний процессын хууль	<p><b>II БҮЛЭГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ГОМДОЛ ГАРГАХ</b>  <b>422 дугаар зүйл (Хяналтын гомдол)</b>  (1) Дээд шатны шүүхийн эцсийн шийдвэр, эсвэл дүүргийн 2 шатны шүүхийн гаргасан эцсийн шийдвэрийн эсрэг Улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргаж болно.  (2) 390-р зүйлийн 1-д заасан тохиолдолд анхан шатны шүүхийн эцсийн шийдвэрийн эсрэг Дээд шүүхэд хяналтын гомдол гаргаж болно.  <b>423 дугаар зүйл (Улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргах үндэслэл)</b>  Үндсэн хууль, хууль тогтоомж, захиргааны акт, журам зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзсэн тохиолдолд Улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргаж болно.  <b>424 дүгээр зүйл (Улсын дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл)</b>  (1) Шүүхийн шийдвэрт дараах заалтын аль нэг үндэслэл байгаа тохиолдолд Улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргах үндэслэлтэй гэж үзнэ:  1. Шүүх бүрэлдэхүүнийг хуульд заасан үндэслэлээр байгуулаагүй бол;  2. Хуульд заасан үндэслэлээр шүүх хуралдаанд оролцох эрхгүй шүүгч шүүх хуралдаанд оролцсон бол;  3. Шүүх нь онцгой харьяаллын тухай хуулийн заалтыг зөрчсөн бол;  4. Шүүх хуралдаанд итгэмжлэлээр төлөөлөх, өмгөөлөх эсвэл төлөөлөх тусгай эрх олгох ажиллагааг хуулийн дагуу явуулаагүй тохиолдолд;  5. Шүүх хуралдааныг нээлттэй явуулахтай холбогдох хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд;  6. Шүүхийн шийдвэрийн үндэслэл тодорхойгүй, эсвэл зөрчилтэй нь тогтоогдвол.</p>
2.	Улсын дээд шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмын тухай хууль	<p><b>1-р зүйл (Зорилго)</b>  Энэхүү хуулийн зорилго нь Улсын дээд шүүхийн хяналтын чиг үүргийг оновчтой хэрэгжүүлэх, Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны журмаас үл хамааран шүүх хуралдааныг тасралтгүй явуулахад оршино.  <b>2-р зүйл (Хуулийг хэрэглэх хүрээ)</b>  Иргэний нэхэмжлэл, гэр бүлийн маргаан, захиргааны маргаан (үүнд Патентын тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасан маргааны заалтыг дагаж мөрдөнө, мөн адил цаашид орох өөрчлөлт хамаарна) зэрэгт холбогдуулж Улсын дээд шүүхэд гаргасан гомдол нь энэ хуулийн зохицуулалтад хамаарна.  <b>3 дугаар зүйл (Иргэний процессын хуулийг хэрэглэхгүй тохиолдол)</b>  Иргэний процессын хуулийн зүйл заалтууд (үүнд хуулийн нэмэлт өөрчлөлтүүд, түүнтэй холбогдон гарсан актууд мөн адил хамаарна) энэ хуулийн аль нэг заалттай зөрчилдсөн тохиолдолд энэхүү хуулийг хэрэглэнэ.  <b>4 дүгээр зүйл (Шүүх хуралдааныг түдгэлзүүлэх)</b></p>

<sup>8</sup> Act On Special Cases Concerning Procedure For Trial By The Supreme Court, <https://www.law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=act+on+special+supreme+court&x=0&y=0#liBgcolor0>, (Сүүлд үзсэн: 2022.09.28).

<sup>9</sup> Civil Procedure Act, <https://www.law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2&query=act%20on%20special%20procedure%20supreme%20court#liBgcolor0>, (Сүүлд үзсэн: 2022.09.28).

	<p>(1) Улсын Дээд шүүхэд гаргасан хяналтын гомдлыг дараах үндэслэлүүдийн аль нэг нь байгаа тохиолдолд хэлэлцэхээс түдгэлзүүлж, гомдлыг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргана:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүхийн шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн, эсвэл Үндсэн хуулийг үндэслэлгүй тайлбарласан бол;</li> <li>2. Шүүхээс хууль, тушаал, дүрэм, захирамжийг хууль зөрчсөн эсэх талаар шийдвэрлэхдээ хуулийг тайлбарлан хэрэглэсэн нь үндэслэлгүй тохиолдолд;</li> <li>3. Шүүх нь хууль, тушаал, дүрэм, захирамжийг Улсын дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарлан хэрэглэсэн бол;</li> <li>4. Аливаа хууль, тушаал, дүрэм, захирамжийг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн тайлбар байхгүй эсвэл Улсын дээд шүүхийн тайлбарыг өөрчлөх шаардлагатай бол;</li> <li>5. 1-ээс 4-р дэд зүйлд заасан заалтаас гадна аливаа журам, бусад хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн тохиолдолд;</li> <li>6. Иргэний процессын хуулийн 424 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ээс 5 дахь хэсэгт заасан үндэслэл байгаа тохиолдолд.</li> </ol>
--	---

Хуулийн зохицуулалтаас үзвэл БНСУ-ын Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргахтай холбогдсон харилцааг Улсын дээд шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмын тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байна гэж үзэх үндэслэлтэйн дээр тус хуулийн зохицуулалтад Иргэний процессын хуульд заасан хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийн зохицуулалтыг эшилж тус зохицуулалтын дагуу гомдол гаргах боломжтой байхаар зохицуулсан онцлогтой байна.

Түүнчлэн хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлд шүүхийн шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол, шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй тохиолдолд Улсын дээд шүүхэд хандан хяналтын журмаар гомдол гаргах эрхийг олгосон нь сайшаалтай байх ба шүүхээс аливаа хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлан хэрэглэсэн тохиолдолд хяналтын гомдол гаргахаар хуульчилсан нь Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.7.6 дэх заалтад “Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх: хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн”, ИХШХШтХ-ийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана: шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” гэсэнтэй адил төсөөтэй байна гэж үзлээ.

### 3. БНТУ

БНТУ-ын хувьд шүүх эрх мэдлийн дээд байгууллага нь Улсын дээд шүүх (The Court of Cassation)<sup>10</sup> ба тус шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан тохиолдолд хянах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг иргэний болон эрүүгийн хэргийн

<sup>10</sup> **Франц Улсын** хувьд шүүх эрх мэдлийн дээд байгууллага буюу Улсын дээд шүүхийг ийнхүү нэрлэдэг ба тус улсын хувьд Улсын дээд шүүх нь Шүүхийн тухай хуульд заасан үндсэн зарчмыг баримтлан **эрх зүйн практикийг нэгтгэх /шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг хангах/, нэг хуулийг тухайн улсын нутаг дэвсгэр дээр нэг янзаар ойлгохоор тайлбарлах гэх мэт үндсэн чиг үүрэгтэй**. Мөн шийдвэр гаргахдаа тухайн маргааныг хянах бус, шүүхийн бие даасан байдалд хүндэтгэлтэй хандаж, **шийдвэр гаргахдаа шүүхээс хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэхийг хянадаг байна**. <https://www.courdecassation.fr/en/about-court>. (Сүүлд үзсэн: 2022.09.29).

шүүхээс гаргасан, хуулиар бусад шүүхийн байгууллагад шилжүүлээгүй шийдвэр, магадлалыг хянан шийдвэрлэх хамгийн сүүлийн шатны шүүх юм.<sup>11</sup>

Бусад гадаад улсын хяналтын шатны шүүх буюу Улсын дээд шүүхээс ялгаатай нь БНТУ-ын хувьд Улсын дээд шүүх нь дотроо Иргэний хэргийн 23 танхим, Эрүүгийн хэргийн 15 танхимтай ба дээрх танхимын хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хянадаг. Танхим бүрд ерөнхийлөгчөөс гадна хангалттай тооны гишүүд хамтран ажиллахыг зэрэгцээ илтгэгч шүүгчид хэргийн материалтай танилцах, нийт шүүгчдийн хуралдаан эсвэл Танхимд танилцуулах илтгэл бэлтгэх үүрэг даалгавар өгдөг байна.<sup>12</sup>

#### 4. ОХУ

ОХУ-ын Үндсэн хуулийн 126 дугаар зүйлд зааснаар: ОХУ-ын Дээд шүүх нь “иргэний хэрэг, арилжааны маргаан, эрүүгийн, захиргааны болон Холбооны Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан ерөнхий харьяаллын шүүх, арилжааны шүүхийн харьяалагдах хэргийг хянан шийдвэрлэдэг, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг шүүхийн дээд байгууллага юм.” гэжээ.

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай хууль <sup>13</sup>	<p><i>19 дүгээр зүйлийн 1-д зааснаар:</i> Оросын Холбооны Дээд шүүх нь энэхүү Холбооны Үндсэн хуулийн хуульд заасны дагуу иргэний хэрэг, эдийн засгийн маргаан, эрүү, захиргааны болон бусад хэргийг хянан шийдвэрлэдэг шүүх эрх мэдлийн дээд байгууллага юм.</p> <p><i>19 дүгээр зүйлийн 2-т зааснаар:</i> Оросын Холбооны Дээд шүүх нь Холбооны хуульд заасанчлан байцаан шийтгэх ажиллагааны хэлбэрийг ашиглан иргэний хэрэг, эдийн засгийн маргаан, эрүүгийн, захиргааны болон бусад хэргийг хянан шийдвэрлэх замаар Холбооны Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдсан шүүхүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангадаг. Дээр дурьдсанаар, хяналтын шатны шүүхийн бүрэн эрхийн хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүх харьяалагдана.</p> <p><i>19 дүгээр зүйлийн 3-т зааснаар:</i> Оросын Холбооны Дээд шүүх нь анхан шатны шүүхэд харьяалагдаж буй хэргүүдийг, мөн шинэ буюу шинээр илэрсэн нотлох баримтыг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэдэг.</p> <p><i>19 дүгээр зүйлийн 4-т зааснаар:</i> ОХУ-ын Дээд шүүх нь Бүгд Найрамдах улсын Дээд шүүх, бүс нутгийн шүүх, холбооны орон нутгийн захиргааны шүүх, автономит муж, цэргийн тойрог, флот, зэвсэг, болон цэргийн ангиудын нэгдсэн цэргийн шүүхүүдээс шүүх эрх мэдлийн хувьд дээгүүр байна.</p> <p><i>19 дүгээр зүйлийн 5-д зааснаар:</i> ОХУ-ын хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, хэрэглэх явдлыг хангахын тулд ОХУ-ын Дээд шүүх нь хуулийн албан ёсны тайлбар гаргах эрхтэй.</p> <p><i>19 дүгээр зүйлийн 6-д зааснаар:</i> Оросын Холбооны Дээд шүүхийн бүрэн эрх, түүнийг байгуулах хэлбэр, үйл ажиллагааг ОХУ-ын Холбооны Үндсэн хуульд зохицуулсан.</p>
2.	ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан	<p><i>390 дүгээр зүйл. Хяналтын шатны шүүхийн бүрэн эрх.</i></p> <p>1. Шүүх хэргийг хяналтын журмаар хэлэлцэх дараах эрхтэй:</p> <p>а) Анхан шатны шүүх, Хоёр дах шүүх, Хяналтын шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахгүйгээр хэвээр үлдээх, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэх тухай улсын яллагчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхих;</p>

<sup>11</sup> The Judicial System of Turkey and Organization of The Ministry of Justice, [https://diabgm.adalet.gov.tr/Resimler/SayfaDokuman/2492019170148THE\\_JUDICIAL\\_SYSTEM\\_OF\\_TURKEY\\_AND\\_ORGANISATION\\_OF\\_THE\\_MINISTRY\\_OF\\_JUSTICE.pdf](https://diabgm.adalet.gov.tr/Resimler/SayfaDokuman/2492019170148THE_JUDICIAL_SYSTEM_OF_TURKEY_AND_ORGANISATION_OF_THE_MINISTRY_OF_JUSTICE.pdf), (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<sup>12</sup> Мөн тэнд. Эшлэл 11.

<sup>13</sup> [https://www.wto.org/english/thewto\\_e/acc\\_e/rus\\_e/wtaccrus48a5\\_leg\\_80.pdf](https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus48a5_leg_80.pdf), (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<p><b>шийдвэрлэх тухай хууль<sup>14</sup></b></p>	<p>b) Анхан шатны шүүх, Хоёр дах шүүх, Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах;</p> <p>c) Анхан шатны шүүх, Хоёр дах шүүх, Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож, гомдлыг хэлэлцэхгүй орхих, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох;</p> <p>d) Хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийн аль нэгийг /3 шатны шүүхийн шийдвэрүүдийн аль нэг/ хүчингүй болгох;</p> <p>e) Материаллаг хуулийн хэм хэмжээг хэрэглэх, мөн тайлбарлахдаа алдаа гаргасан бол хэргийг шинээр дахин хэлэлцүүлэхээр явуулалгүй шинээр шүүхийн шийдвэр үйлдэн анхан шатны шүүх, хоёр дах шатны шүүх, болон хяналтын шатны шүүхүүдийн шийдвэрийг хүчингүй болгож, өөрчлөх</p> <p>f) энэ хуулийн 379.1-д заасан үндэслэл байвал хяналтын журмаар гаргасан, улсын яллагчийн танилцуулгын гомдлыг хянан шийдвэрлэхгүй орхих.</p> <p>1.1. Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхдээ Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хяналтын гомдол, прокурорын гаргасан танилцуулгын хүрээнд бодит үндэслэлтэйгээр болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэж, мөн тайлбарласан эсэхийг хянан шалгана. Хууль ёсны ашиг сонирхлын үүднээс хяналтын шатны шүүх нь хяналтын гомдол, прокурорын гаргасан тайлбарын үндэслэлд өөрчлөлт оруулан шийдвэр гаргах эрхтэй. (зөрчиж?)</p> <p>2. Дээд шатны шүүхийн гаргасан хуулийн тайлбар нь хэргийг шинээр хянан хэлэлцэж байгаа шүүх заавал хэрэглэх ёстой.</p>
	<p>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 376 дугаар зүйлийн 1, 2 болон 3 дугаар хэсгүүдэд заасны дагуу Хяналтын шатны шүүхэд давж заалдах эрхтэй:</p> <p>1. Шүүхийн хууль ёсны хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг (ОХУ-ын Дээд шүүхийн шүүгчдийн гаргасан шийдвэрээс бусад шийдвэр) энэ бүлэгт заасан журмын дагуу шүүхийн шийдвэрээр хэргийн оролцогч, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд хяналтын шатны шүүхэд давж заалдах эрхтэй.</p> <p>2. Эдгээр этгээдүүд нь энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрийг хууль ёсны хүчин төгөлдөр болохоос өмнө давж заалдах гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр хууль ёсны хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор хяналтын шатны шүүхэд давж заалдаж болно.</p> <p>3. Хэргийг хянан хэлэлцэхэд улсын яллагч оролцсон бол магадлалыг шинэчлэн тогтоолгохоор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Шүүхийн хууль ёсны хүчин төгөлдөр болсон тогтоол нь энэ хуулийн 377 дугаар зүйлд заасан прокурорын байгууллагын албан тушаалтанд хамаарна.</p>

Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааны онцлогтой хамааралтайгаар ОХУ-д иргэний хэргийн тангарагтны шүүх хурал болдоггүй. Хэргийн асуудалтай холбогдолтойгоор нарийн төвөгтэй буюу ялангуяа эдийн засаг, санхүү, бизнесийн удирдлагын чиглэлийн мэргэжлийн мэдлэг шаардсан хэрэг маргаан үүссэн тохиолдолд талуудын аль нэг нь хүсэлт гаргасан бол ОХУ-ын арбитрын анхан шатны шүүх нь шүүгч, хоёр арбитрын шүүхийн шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг<sup>15</sup>.

ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын ИХШХШТХ-ийн зохицуулалттай харьцуулан үзвэл, ОХУ-ын хяналтын шатны шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зохицуулалт нь нэлээд

<sup>14</sup> [https://www.wto.org/english/thewto\\_e/acc\\_e/rus\\_e/wtaccrus58\\_leg\\_62.pdf](https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus58_leg_62.pdf) (Сүүлд үзсэн: 2022.09.29).

<sup>15</sup> [Litigation: Russia - Global Arbitration Review](#), (Сүүлд үзсэн: 2022.09.29).

дэлгэрэнгүй байх бөгөөд зөвхөн хяналтын гомдлыг авч хэлэлцэх бус, эрх зүйн салбар бүрд давж заалдах эрхийнхээ хүрээнд хяналтын гомдол гаргах, прокурор хяналтын журмаар гомдол гаргах эрхтэйгээр зохицуулсан онцлогтой байна.

Мөн түүнчлэн ОХУ-ын хяналтын шатны шүүх буюу Оросын Холбооны Дээд шүүх нь өөрийн улсын нутаг дэвсгэр дээр хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд тайлбар гаргах хуульд заасан эрх бүхий субъект байна. Энэ нь Монгол Улсын хуульд заасан УДШ-ийн бүрэн, эрх чиг үүргийн зохицуулалттай агуулгын хувьд дүйж байна гэж үзсэн болно.

Мөн түүнчлэн хяналтын журмаар гомдол гаргах эрх бүхий субъектүүдийг нэлээдгүй өргөн хүрээтэй хуульчилсан зохицуулалтын хувьд манай улсын ИХШХШТХ-ийн 172 дугаар зүйлийн 172.1 дэх хэсэгт “зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтыг журмаар гомдол гаргах эрхтэй” гэж зохицуулсантай адил төсөөтэй болжээ.

## ГУРАВ. ТООН МЭДЭЭЛЭЛ

Энэ хэсэгт иргэний хэргийн анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, УДШ-ийн Иргэний хэргийн танхимаас сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2017 оноос 2021 оныг хүртэлх хугацаанд хянан шийдвэрлэсэн нийт хэрэг маргааны тоон мэдээллийг судлан гаргасныг доорх хүснэгтээр үзүүлбэл:

	<i>Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн маргааны тоо<sup>16</sup></i>	<i>Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн маргааны тоо<sup>17</sup></i>	<i>Хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн маргааны тоо<sup>18</sup></i>
<b>2017</b>	45.233	3721	1043
<b>2018</b>	48.155	3401	1818
<b>2019</b>	43.397	3082	840
<b>2020</b>	53.678	3394	1104
<b>2021</b>	45.444	2529	1783

Сүүлийн 3 жилд буюу 2019-өөс оноос 2021 оныг хүртэлх хугацаанд Иргэний хэргийн анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт маргааны тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, иргэний хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдлын талаар **ШЕЗ-өөс гаргасан Монгол Улсын шүүхийн тайлан 2020-д<sup>19</sup>**: “**Анхан шатны шүүх** 2020 онд эрүүгийн 13470 хэрэг, **иргэний 53678 хэрэг**, захиргааны 1524 хэрэг, зөрчлийн 20963 хэрэг нийт 89635 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 1412 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, 2969 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 0.3 хувиар, **иргэний хэрэг 23.7 хувиар тус тус өссөн** бол захиргааны хэрэг 12.8 хувиар буурсан байна.” гэж дурджээ.

**Иргэний хэргийн анхан шатны шүүх 2020 онд** нийт 74684 нэхэмжлэл, гомдол,

<sup>16</sup> Энэхүү тоон мэдээллийг УДШ-ийн Практик судалгааны хэлтсээс ШССМХ-д ирүүлсэн материалд үндэслэн гаргасан болно.

<sup>17</sup> 2020 болон 2021 онд хянан шийдвэрлэгдсэн нийт маргааны тоон мэдээллийг ШЕЗ-өөс гаргасан “Монгол Улсын шүүхийн тайлан 2020, 2021” гэсэн тайлангаас 2018 онд хянан шийдвэрлэгдсэн нийт маргааны тоон мэдээллийг Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д хайлт хийн, 2017, 2019 онд холбогдох тоон мэдээг УДШ-ийн Практик судалгааны хэлтсээс ШССМХ-д материалд үндэслэн гаргасан болно.

<sup>18</sup> 2020 болон 2021 онд хянан шийдвэрлэгдсэн нийт маргааны тоон мэдээллийг ШЕЗ-өөс гаргасан “Монгол Улсын шүүхийн тайлан 2020, 2021” гэсэн тайлангаас авсан бол бусад онд холбогдох тоон мэдээллийг Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д хайлт хийн гаргасан болно.

<sup>19</sup> [file:///C:/Users/etern/Downloads/SHYZuvlul%20tailan\\_2020.pdf](file:///C:/Users/etern/Downloads/SHYZuvlul%20tailan_2020.pdf), (Сүүлд үзсэн: 2022.09.27).

хүсэлт хүлээн авснаас 13194 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас




График 1. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн  
графикаар харуулав:

харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг **7812 хэргийн үлдэгдэлтэй байна.** Үүнийг доорх




График 2. Шийдвэрлэсэн хэргийг 2019 онтой харьцуулсан байдал

**Давж заалдах шатны шүүх 2020 онд** эрүүгийн 2702 хэрэг, **иргэний 3436 хэрэг**, захиргааны 1104 хэрэг, зөрчлийн хэрэг 400 нийт 8013 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2019 оноос 18.2 хувиар, **иргэний хэрэг 9.3 хувиар**, захиргааны хэрэг 26.4 хувиар тус тус **өссөн үзүүлэлттэй гарсан байна.**

**Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх** нийт **3839 хэрэг хүлээн авч, 3394 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж**, 76 хэргийн давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 33 хэрэгт давж заалдах гомдлоосоо татгалзсан бөгөөд 32 хэргийн арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэж, 10 хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянасан байна.

Тайлант хугацааны эцэст иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд **294 хэргийн** үлдэгдэлтэй байжээ.



График 3. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн




График 4. Шийдвэрлэсэн хэргийг өмнөх онтой харьцуулсан байдал

**Шийдвэрлэгдсэн байдлын хувьд:** Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн **1529 хэрэг буюу 45.1 хувьд** нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, **1167 хэрэг буюу 34.4 хувьд** нь шийдвэрт өөрчлөлт оруулж, **698 хэрэг буюу 20.5 хувьд** нь шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

#### ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2020 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН /АНХАН ШАТНЫ ШҮҮХ/

Анхан шатны шүүх 2020 онд нийт 74684 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 13194 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, татан авах, нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, 53678 хэргийг хянан шийдвэрлэж, 7812 хэргийн үлдэгдэлтэй байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 10281 хэрэг буюу 23.7 хувиар өссөн байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх тайлант хугацаанд нийт 26466 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 49.3 хувийг эзэлж байгаа бөгөөд Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 5716 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 10.6 хувийг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4448 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 8.3 хувийг, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4441 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 8.3 тус тус эзэлж байна.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд Хөвсгөл аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2260 хэрэг буюу 4.2 хувь, Төв аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1756 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 3.3 хувь, Орхон аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1698 хэрэг буюу 3.2 хувийг тус тус эзэлсэн нь хамгийн өндөр байна. Харин сум дундын шүүхээс Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх 597 хэрэг, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх 575 хэрэг тус тус шийдвэрлэсэн сум дундын шүүхийн шийдвэрлэсэн хэргээс хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг


№	ШҮҮХ	Он		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1.	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	805	1173	368	45.7
2.	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	800	1308	508	63.5
3.	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	997	1304	307	30.8
4.	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	712	1083	371	52.1
5.	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	451	909	458	101.6
6.	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	212	252	40	18.9
7.	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1290	1380	90	7.0
8.	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	424	526	102	24.1
9.	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1032	1418	386	37.4
10.	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	558	907	349	62.5
11.	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	538	776	238	44.2
12.	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1760	1698	-62	-3.5
13.	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	398	647	249	62.6
14.	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	726	976	250	34.4
15.	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	535	739	204	38.1
16.	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	701	744	43	6.1
17.	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1460	1756	296	20.3
18.	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	562	865	303	53.9
19.	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	682	923	241	35.3
20.	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1302	2260	958	73.6
21.	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	784	958	174	22.2
22.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	294	419	125	42.5
23.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	336	517	181	53.9
24.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	154	261	107	69.5
25.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	376	597	221	58.8

26.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	448	575	127	28.3
27.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	201	284	83	41.3
28.	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	249	344	95	38.2
29.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	178	279	101	56.7
30.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	5159	5716	557	10.8
31.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3478	3906	428	12.3
32.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2983	3662	679	22.8
33.	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4098	4293	195	4.8
34.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3755	4441	686	18.3
35.	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3861	4448	587	15.2
36.	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	574	704	130	22.6
37.	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	492	578	86	17.5
38.	Баганхангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	32	52	20	62.5
	<b>Нийт</b>	<b>43397</b>	<b>53678</b>	<b>10281</b>	<b>23.7</b>

**Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал:** Тайлант хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 53678 иргэний хэргийн 30651 хэрэг буюу 57.1 хувийг нь ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бол 15738 хэрэг буюу 29.3 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 7289 хэрэг буюу 13.6 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгожээ.

2019 онтой харьцуулахад ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 4021 хэрэг буюу 34.3 хувиар, ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 1279 хэргээр буюу 21.3 хувиар, ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэргийн тоо 4981 хэрэг буюу 19.4 хувиар тус тус өсжээ.

*График 5. Иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн байдал*




Шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн **нийт 30651 хэргээс** 24810 хэрэг буюу 80.9 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, 3926 хэрэг буюу 12.8 хувьд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол 1915 хэрэг буюу 6.3 хувьд нэхэмжлэлийг бүхэлд

нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

**Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл:** Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 25365 буюу 47.3 хувийг, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 19237 буюу 35.8 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4732 буюу 8.8 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 1173 буюу 2.2 хувийг тус тус эзэлжээ.

График 6. Шийдвэрлэсэн хэрэг (Хуулиар)



**Иргэний хуулиар нийт 25365 хэрэг шийдвэрлэсэн** нь өмнөх оноос 4741 хэргээр буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 1633 хэргээр буюу 27.5 хувиар, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 1471 хэргээр буюу 2.3 дахин, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 1196 хэргээр буюу 69.5 хувиар, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан 142 хэргээр буюу 28.2 хувиар, зээлийн гэрээтэй холбоотой маргаан 108 хэргээр буюу 1.9 хувиар, хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлтэй холбоотой маргаан 105 хэргээр буюу 61.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Харин **ИХШХШТХ-иар 19237 хэрэг шийдвэрлэсэн** нь өмнөх онтой харьцуулахад 4583 хэргээр буюу 31.3 хувиар өссөн байх бөгөөд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 35.8 хувийг эзэлжээ. Үүнийг задалж авч үзвэл онцгой ажиллагааны журмаар 17034 хэрэг шийдвэрлэсэн бол үүнээс ажилласан жил тогтоосон 11641 хэрэг шийдвэрлэж өмнөх оноос 4115 буюу 54.7 хувиар, хамтын амьдралтай байсныг тогтоосон 752 хэрэг шийдвэрлэж өмнөх оноос 266 хэргээр буюу 54.7 хувиар тус тус өссөн байна.

Хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаанаас Гэр бүлийн тухай хуулиар 4732 хэрэг шийдвэрлэж өмнөх оны мөн үеэс 283 хэргээр буюу 6.4 хувиар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 143 хэргээр буюу 41.3 хувиар, Цагаатгалын нөхөн олговортой холбоотой маргаан 292 хэргээр буюу 46.6 хувиар тус тус **өссөн** бол Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 129 хэргээр буюу 9.9 хувиар, Газрын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 33 хэргээр буюу 22.6 хувиар, Дампуурлын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 10 хэргээр буюу 40 хувиар, Компанийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 2 хэргээр буюу 8.3 хувиар, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 19 хэргээр буюу 5.7 хувиар, Татварын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 123 хэргээр буюу 60.9 хувиар тус тус **буурсан**.

**ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2020 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН  
/ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ/**

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд улсын хэмжээнд 2020 онд нийт 3839 хэрэг хүлээн авч, 3394 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэнээс 1529 хэрэг буюу 45.1 хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 1167 хэрэг буюу 34.4 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 698 хэрэг буюу 20.5 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 294 хэргийн үлдэгдэлтэй байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг

хянуулах нийт 10 хүсэлт гаргаснаас 10 хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай 32 хүсэлтийг хянан шийдвэрлэснээс арбитрын 6 шийдвэрийг хүчингүй болгож, 26 шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Нийт 176 хэрэгт давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 33 хэрэгт эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзаж буцаан авсан байна. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоо 2019 онтой харьцуулахад 312 хэргээр буюу 10.1 хувиар өсжээ.

*Хүснэгт 2. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн байдал*

№	Маргааны төрөл	Он		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1.	Нийт /хүлээн авсан/	3427	3839	412	12
2.	Нийт шийдвэрлэсэн	3144	3436	292	9.3
3.	Хянан шийдвэрлэсэн хэрэг бүгд	3082	3394	312	10.1
4.	Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	35	32	-3	-8.6
5.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	27	10	-17	-63
6.	Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан	106	76	-30	-28.3
7.	Давж заалдах гомдлоосоо татгалзсан	29	33	4	13.8
8.	Үлдэгдэл	148	294	146	98.6

**Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг:** Давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн нийт хэргийн 2431 хэрэг буюу 71.6 хувийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 139 хэрэг буюу 4.1 хувийг Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 126 хэрэг буюу 3.7 хувийг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 88 хэрэг буюу 2.6 хувийг Баян-Өлгий аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 72 хэрэг буюу 2.1 хувийг Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 84.1 хувийг эзэлсэн үзүүлэлттэй байна.

**Шийдвэрийн тогтвортой байдал:** Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлалын тоо 158 хэргээр буюу 11.5 хувиар, өөрчлөлт оруулсан магадлалын тоо 243 хэргээр буюу 26.3 хувиар тус тус **өссөн** бол хүчингүй болгосон магадлалын тоо 89 хэргээр буюу 11.3 хувиар **буурсан** дүнтэй байна.

*Хүснэгт 3. Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал*

№	Хянан шийдвэрлэсэн байдал	Он		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1.	Хэвээр үлдээсэн	1371	1529	158	11.5
2.	Өөрчлөлт оруулсан	924	1167	243	26.3
3.	Хүчингүй болгосон	787	698	-89	-11.3
<b>Нийт</b>		<b>3082</b>	<b>3394</b>	<b>312</b>	<b>10.1</b>

**Өөрчлөлт оруулсан:** 2020 оны анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдлыг авч үзвэл шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр

үлдээсэн буюу өөрчилсөн магадлал 1039 буюу 89 хувь, шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон магадлал 128 хэрэг буюу 11 хувийг тус тус эзэлж байна.

Шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдлыг 2019 онтой харьцуулбал шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн магадлал 346 хэргээр буюу 49.9 хувиар **өсөж**, шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон магадлал 103 хэргээр буюу 44.6 хувиар **буурсан** байна.



График 7. Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдал

**Хүчингүй болгосон:** Шүүхийн статистик мэдээнээс үзвэл “шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлээр хүчингүй болсон 283 хэрэг буюу 40.5 хувь, “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 154 хэрэг буюу 22.1 хувь, “хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” гэх үндэслэлээр 124 хэрэг буюу 17.8 хувь, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” гэх үндэслэлээр 67 хэрэг буюу 9.6 хувь, “ИХШХШТХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 35 хэрэг буюу 5 хувь, “Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 19 хэрэг буюу 2.7 хувь, “Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 9 хэрэг буюу 1.3 хувь, “Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан” гэх үндэслэлээр 4 хэрэг буюу 0.6 хувь, “Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 3 хэрэг буюу 0.4 хувийг тус тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

Үүнээс гадна “Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл өмнөх оноос 33 хэргээр буюу 13.2 хувиар **өсч**, “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл өмнөх оноос 61 хэргээр буюу 28.4 хувиар, “Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” үндэслэл өмнөх оноос 52 хэргээр буюу 29.5 хувиар, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” үндэслэл өмнөх оноос 12 хэргээр буюу 15.2 хувиар тус тус **буурсан** байна.

Хүснэгт 4. Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл

№	Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	О н		Өсөлт, бууралт		Хүчингүй болсон хэрэгт эзлэх хувь		Зөр үү
		2019 он	2020 он	Тоо	Хувь	2019 он	2020 он	Тоо

1.	Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	250	283	33	13.2	31.8	40.5	8.8
2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	23	19	-4	-17.4	2.9	2.7	-0.2
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн	176	124	-52	-29.5	22.4	17.8	-4.6
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	14	9	-5	-35.7	1.8	1.3	-0.5
5.	Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	2	4	2	100.0	0.3	0.6	0.3
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	1	3	2	200.0	0.1	0.4	0.3
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн	215	154	-61	-28.4	27.3	22.1	-5.3
8.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	79	67	-12	-15.2	10.0	9.6	-0.4
9.	ИХШХШТХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн	27	35	8	29.6	3.4	5.0	1.6
<b>Нийт</b>		<b>787</b>	<b>698</b>	<b>-89</b>	<b>-11.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>

Давж заалдах шатны шүүх дэх иргэний хэргийн үлдэгдэл 294 хэрэг буюу 2019 онтой харьцуулбал 146 хэргээр буюу 98.6 хувиар өсжээ. Хэргийн үлдэгдлээс Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 241 хэрэг буюу нийт үлдэгдлийн 82 хувийг эзэлсэн байна.

<b>ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2020 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН /ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ/</b>	
Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 38 хэрэг дээр хяналтын шатны журмаар шинээр ирсэн 912 хэрэг, ерөнхий шүүгчид гомдол гаргасан 96, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүсэлттэй 74 хэрэг, нийт 1120 хэрэг хүлээн авснаас 1104 хэргийг хянан шийдвэрлэж, 16 хэргийн үлдэгдэлтэй байна.	
Хуралдаанд оруулаагүй шийдвэрлэсэн хэрэг 182 буюу 16.5 хувь, хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг 846 буюу 76.6 хувь, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн хэрэг 76 буюу 6.9 хувийг тус тус эзэлж байна.	

Хүснэгт 5. Хяналтын шатны шүүхийн иргэний хэрэг

№	Үзүүлэлт	О н		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1.	Хүлээн авсан хэрэг	1370	1120	-250	-18.2
2.	Хянан шийдвэрлэсэн хэрэг	1332	1104	-228	-17.1

3.	Хянаад хариу өгсөн хэрэг /Хуралдаанд оруулахгүй шийдвэрлэсэн/	292	182	-110	-37.7	
4.	Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	-	-			
5.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	36	76	40	111.1	
6.	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	1004	846	-158	-15.7	
7.	Үүнээс:	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон	634	479	-155	-24.4
8.		Шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан	142	188	46	32.4
9.		Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн	101	78	-23	-22.8
10.		Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон	15	18	3	20.0
11.		Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	11	19	8	72.7
12.		Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	101	64	-37	-36.6
13.		Үлдэгдэл	38	16	-22	-57.9

Хяналтын шатны шүүх нийт 846 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон нь 479 хэрэг буюу 56.6 хувь, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан нь 188 хэрэг буюу 22.2 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн нь 78 хэрэг буюу 9.2 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон нь 18 хэрэг буюу 2.1 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь 19 хэрэг буюу 2.2 хувь, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 64 хэрэг буюу 7.6 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нийт хэрэгт “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж, хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 33 хэрэг буюу 51.6 хувийг, “Шүүх өөр хуулийг эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл 26 хэрэг буюу 40.6 хувийг, “Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” үндэслэл 5 хэрэг буюу 7.8 хувийг тус тус эзэлсэн байна.

*Хүснэгт 6. Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл*

№	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл	О Н		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1.	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	55	26	-29	-52.9
2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан	0	0	-	-

	шийдвэрлэсэн				
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн	9	5	-4	-44.4
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	1	0	-1	-
5.	Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	0	-	-
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	10	0	-10	-
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн	26	33	7	26.9
	<b>Нийт</b>	<b>101</b>	<b>64</b>	<b>-37</b>	<b>-36.6</b>

Тайлант хугацааны эцэст 16 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 22 хэргээр буюу 57.9 хувиар буурсан байна. Үүнээс хугацаа хэтэрсэн үлдэгдэл 5 хэрэг байна.

**ШЕЗ-өөс гаргасан Монгол Улсын шүүхийн тайлан 2021-д<sup>20</sup>: “Анхан шатны шүүх 2021 онд** эрүүгийн 12068 хэрэг, **иргэний 45444 хэрэг**, захиргааны 1764 хэрэг, зөрчлийн 21946 хэрэг нийт 80417 хэргийг хянан шийдвэрлэж, 1115 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, 2351 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 10.4 хувиар, **иргэний хэрэг 15.3 хувиар тус тус буурсан** бол захиргааны хэрэг 15.7 хувиар, зөрчлийн хэрэг 4.8 хувиар тус тус өссөн байна.” гэж дурджээ.

**Иргэний хэргийн анхан шатны шүүх** 2021 онд нийт 67805 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 13414 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, татан авах, нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, **45444 хэргийг хянан шийдвэрлэж**, 8947 хэргийн үлдэгдэлтэй байна. Үүнийг доорх графикаар харуулав:




График 8. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн




График 9. Шийдвэрлэсэн хэргийг 2020 онтой харьцуулсан байдал

**Давж заалдах шатны шүүх** 2021 онд эрүүгийн 2105 хэрэг, **иргэний 2529 хэрэг**, захиргааны 722 хэрэг, зөрчлийн 468 хэрэг нийт 5824 хэргийг хянан шийдвэрлэжээ. Давж

<sup>20</sup> [file:///C:/Users/etern/Downloads/Shuuihin%20tailan\\_2022-3%20sar%20\(6\).pdf](file:///C:/Users/etern/Downloads/Shuuihin%20tailan_2022-3%20sar%20(6).pdf) Сүүлд үзсэн: 2022.09.28

заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 оноос 22.1 хувиар, **иргэний хэрэг 25.5 хувиар**, зөрчлийн хэрэг 9.3 хувиар тус тус **буурсан** бол захиргааны хэрэг 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.




График 10. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн

График 11. Шийдвэрлэсэн хэргийг 2020 онтой харьцуулсан байдал

**Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2021 онд** нийт 2875 хэрэг хүлээн авч, **2529 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж**, оны эцэст 183 хэргийн үлдэгдэлтэй байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах нийт 16 хүсэлт, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай 28 хүсэлтийг хянан шийдвэрлэж, 38 хэрэгт давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 81 хэрэгт эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзаж буцаан авсан байна.

**Хяналтын шатны шүүх** 2021 онд эрүүгийн 322 хэрэг, **иргэний 1576 хэрэг**, захиргааны 145 хэрэг, нийт 2043 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 53.0 хувиар, захиргааны хэрэг 66.8 хувиар **буурсан** бол **иргэний хэрэг 86.3 хувиар өссөн** дүнтэй гарчээ. Үүнийг доорх графикаар харуулбал:




График 12. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүн

График 13. Шийдвэрлэсэн хэргийг 2020 онтой харьцуулсан байдал

**Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим 2021 онд нийт 2777 хэрэг** хүлээн авснаас, **1576 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж**, 171 хэргийг хуралдаанд оруулахгүй шийдвэрлэж, 875 хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах 36 хүсэлтийг шийдвэрлэж, 119 хэргийн үлдэгдэлтэй байна.

**ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2021 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН  
/АНХАН ШАТНЫ ШҮҮХ/**

Анхан шатны шүүх 2021 онд нийт 67805 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 13414

нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, татанавах, нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, 45444 хэргийг хянан шийдвэрлэж, 8947 хэргийн үлдэгдэлтэй байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өмнөх оноос 8234 хэрэг буюу 15.3 хувиар буурсан байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх тайлант хугацаанд нийт 25673 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 56.5 хувийг эзэлж байгаа бөгөөд Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 5854 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 12.9 хувийг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4208 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 9.3 хувийг, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4165 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 9.2 хувийг, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4150 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 9.1 тус тус эзэлж байна.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд Орхон аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1659 хэрэг буюу 3.7 хувь, Хөвсгөл аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1480 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 3.3 хувь, Дархан-уул аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1442 хэрэг буюу 3.2 хувийг тус тус эзэлсэн нь хамгийн өндөр байна. Харин сум дундын шүүхээс Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх 500 хэрэг, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх 365 хэрэг тус тус шийдвэрлэсэн сум дундын шүүхийн шийдвэрлэсэн хэргээс хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 7. Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг*

№	ШҮҮХ	Он		Өсөлт, бууралт	
		2020 он	2021 он	Тоо	Хувь
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1173	723	-450	-38.4
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1308	1057	-251	-19.2
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1304	851	-453	-34.7
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1083	685	-398	-36.7
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	909	698	-211	-23.2
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	252	179	-73	-29.0
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1380	1442	62	4.5
8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	526	348	-178	-33.8
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1418	974	-444	-31.3
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	907	537	-370	-40.8
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	776	519	-257	-33.1
12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1698	1659	-39	-2.3
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	647	412	-235	-36.3
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	976	551	-425	-43.5

15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	739	506	-233	-31.5
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	744	574	-170	-22.8
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1756	1138	-618	-35.2
18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	865	613	-252	-29.1
19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	923	777	-146	-15.8
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	2260	1480	-780	-34.5
21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	958	685	-273	-28.5
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	419	295	-124	-29.6
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	517	293	-224	-43.3
24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	261	144	-117	-44.8
25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	597	365	-232	-38.9
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	575	500	-75	-13.0
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	284	181	-103	-36.3
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	344	285	-59	-17.2
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	279	227	-52	-18.6
30	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	5716	5854	138	2.4
31	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3906	3482	-424	-10.9
32	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3662	3814	152	4.2
33	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4293	4165	-128	-3.0
34	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4441	4150	-291	-6.6
35	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4448	4208	-240	-5.4
36	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	704	532	-172	-24.4
37	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	578	480	-98	-17.0
38	Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	52	61	9	17.3
	<b>Нийт дүн</b>	<b>53678</b>	<b>45444</b>	<b>-8234</b>	<b>-15.3</b>

**Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал:** Тайлант хугацаанд шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 45444 иргэний хэргийн 22551 хэрэг буюу 49.6 хувийг нь ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бол 15819 хэрэг буюу 34.8 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 7074 хэрэг буюу 15.6 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгожээ.



График 14. Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал

2020 онтой харьцуулахад ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 81 хэрэг буюу 0.5 хувиар өссөн бол ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 215 хэргээр буюу 3 хувиар, ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэргийн тоо 8100 хэрэг буюу 26.4 хувиар тус тус буурчээ.

Шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн нийт 22551 хэргээс 18267 хэрэг буюу 81 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, 2769 хэрэг буюу 12.3 хувьд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол 1515 хэрэг буюу 6.7 хувьд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 15819 хэргээс 5892 хэрэг буюу 37.2 хувьд зохигчид эвлэрсэн, 5674 хэрэг буюу 35.9 хувьд хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, 2910 хэрэг буюу 18.4 хувьд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, 1343 хэрэг буюу 8.5 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл:** Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт **Иргэний хуулиар** шийдвэрлэсэн хэргийн тоо 24531 буюу 54 хувийг, **ИХШХШТХ-иар** шийдвэрлэсэн хэргийн тоо 13433 буюу 29.6 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4690 буюу 10.3 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 1169 буюу 2.6 хувийг тус тус эзэлжээ.




График 15. Шийдвэрлэсэн хэрэг (Хуулиар)

**Иргэний хуулиар** нийт 24531 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 834 хэргээр буюу 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 303 хэргээр буюу 4 хувиар, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 666 хэргээр буюу 22.8 хувиар, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 397 хэргээр буюу 15.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин зээлийн гэрээтэй холбоотой маргаан 934 хэргээр буюу 16.3 хувиар, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан 144 хэргээр буюу 22.3 хувиар, ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаан 79 хэргээр буюу 11.4 хувиар, хөлсөөр ажиллах гэрээтэй холбоотой маргаан 70 хэргээр буюу 48.3 хувиар, хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлтэй холбоотой маргаан 131 хэргээр буюу 47.5 хувиар, гэрээний бус үүрэгтэй холбоотой маргаан 273 хэргээр буюу 30.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Харин **ИХШХШТХ-иар** 13433 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 5804 хэргээр буюу 30.2 хувиар буурсан байх бөгөөд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 29.6 хувийг эзэлжээ. Үүнийг задалж авч үзвэл онцгой ажиллагааны журмаар 11656 хэрэг шийдвэрлэсэн бол үүнээс ажилласан жил тогтоосон 6408 хэрэг шийдвэрлэж өмнөх оноос 5233 хэргээр буюу 45 хувиар буурсан байна.

Хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаанаас Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 42 хэргээр буюу 0.9 хувиар, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4 хэргээр буюу 0.3 хувиар, Газрын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 9 хэргээр буюу 8 хувиар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 73 хэргээр буюу 14.9 хувиар, Татварын ерөнхий хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 57 хэргээр буюу 72.2 хувиар, Цагаатгалын нөхөн олговортой холбоотой маргаан 691 хэргээр буюу 75.2 хувиар, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 213 хэргээр буюу 67.6 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

*Хүснэгт 8. Хэрэг, маргааны төрөл*

№	Хэрэг, маргааны төрөл	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү (+), (-)
				Тоо	Хувь	2020 он	2021 он	
	<b>Нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг</b>	<b>53678</b>	<b>45444</b>	<b>-8234</b>	<b>-15.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>
1	Иргэний эрх зүйн маргаан	25365	24531	-834	-3.3	47.3	54.0	6.7
2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	19237	13433	-5804	-30.2	35.8	29.6	-6.3
3	Гэр бүлийн эрх зүйн маргаан	4732	4690	-42	-0.9	8.8	10.3	1.5
4	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	1173	1169	-4	-0.3	2.2	2.6	0.4
5	Газрын тухай хуулиар	113	104	-9	-8.0	0.2	0.2	0.0
6	Дампуурлын тухай хуулиар	15	15	0	0.0	0.0	0.0	0.0
7	Компанийн тухай хуулиар	22	21	-1	-4.5	0.0	0.0	0.0
8	Нийгмийн даатгалын багц хуулиар	315	102	-213	-67.6	0.6	0.2	-0.4
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	489	416	-73	-14.9	0.9	0.9	0.0
10	Татварын ерөнхий хуулиар	79	22	-57	-72.2	0.1	0.0	-0.1
11	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	6	6	0	0.0	0.0	0.0	0.0
12	Төрийн албаны тухай хуулиар	4	23	19	475.0	0.0	0.1	0.0
13	Цагаатгалын нөхөн олговор	919	228	-691	-75.2	1.7	0.5	-1.2
14.	Бусад хуулиар	1209	684	-525	-43.4	2.3	1.5	-0.7

Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийн тухайд гэрлэлт цуцлахтай холбоотой 2823 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулбал 97 хэргээр буюу 3.6 хувиар өссөн бол хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой 1297 хэрэг шийдвэрлэсэн нь 36 хэргээр буюу 2.7 хувиар, эцэг тогтоохтой холбоотой 331 хэрэг шийдвэрлэсэн нь 71 хэргээр буюу 17.7 хувиар, эцэг, эх байх эрх хасахтай холбоотой 16 хэрэг шийдвэрлэсэн нь 4 хэргээр буюу 20 хувиар, гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцохтой холбоотой 23 хэрэг шийдвэрлэсэн нь 2 хэргээр буюу 8 хувиар тус тус буурчээ.

Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийн тухайд ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 628 шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулбал 15хэргээр буюу 2.4 хувиар өссөн бол цалин хөлсний маргаан 355 шийдвэрлэсэн нь 31 хэргээр буюу 8 хувиар, ажлаас буруу шилжүүлсэн хэрэг 24 шийдвэрлэсэн нь өмнөх оноос 41 хэргээр буюу 63.1 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 9. Хэрэг, маргааны төрөл, шүүхээр

№	ШҮҮХ	Иргэний эрх зүйн маргаан	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	Бусад эрх зүйн маргаан	Нийт
1.	Архангай аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	184	451	62	18	8	723
2.	Баян-Өлгий аймаг дахь сум дундыниргэний хэргийн анхан шатны шүүх	328	551	65	81	32	1057
3.	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	206	499	129	14	3	851
4.	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	283	304	63	25	10	685
5.	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	136	429	33	42	58	698
6.	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	101	26	35	3	14	179
7.	Дархан-Уул аймаг дахь сум дундыниргэний хэргийн анхан шатны шүүх	821	359	195	32	35	1442
8.	Дорноговь аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	119	126	81	8	14	348
9.	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	482	227	146	21	98	974
10.	Дундговь аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	109	315	62	15	36	537
11.	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	104	356	40	18	1	519
12.	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1127	280	199	47	6	1659
13.	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	147	165	81	2	17	412
14.	Өвөрхангай аймаг дахь сум дундыниргэний хэргийн анхан шатны шүүх	182	278	84	2	5	551

15.	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	108	290	75	17	16	506
16.	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	324	161	78	5	6	574
17.	Төв аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	379	630	90	19	20	1138
18.	Увс аймаг дахь сум дундын иргэнийхэргийн анхан шатны шүүх	287	224	56	40	6	613
19.	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	164	364	66	25	158	777
20.	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	437	776	216	39	12	1480
21.	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	354	269	53	3	6	685
22.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	157	87	48	2	1	295
23.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	48	214	22	6	3	293
24.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	59	50	26	6	3	144
25.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	98	232	27	5	3	365
26.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	307	126	63	1	3	500
27.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	109	40	21	4	7	181
28.	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	93	174	9	4	5	285
29.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	150	45	26	2	4	227
30.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4201	655	599	150	249	5854
31.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1917	931	256	149	229	3482
32.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1902	1507	192	112	101	3814
33.	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2788	679	422	112	164	4165
34.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2729	790	389	97	145	4150
35.	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2875	657	557	33	86	4208
36.	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	352	91	55	4	30	532
37.	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	326	66	63	6	19	480
38.	Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	38	9	6		8	61
	<b>Нийт дүн</b>	<b>24531</b>	<b>13433</b>	<b>4690</b>	<b>1169</b>	<b>1621</b>	<b>45444</b>

**Хэргийн үлдэгдэл:** Тайлант хугацааны эцэст анхан шатны шүүхүүд 8947 иргэний хэргийн үлдэгдэлтэй байна. Үүнээс хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж буй 5397 буюу 60.3 хувь, шүүх хуралдаан хойшлуулсан 916 хэрэг буюу 10.2 хувь, түдгэлзүүлсэн 1263 хэрэг буюу 14.1 хувь, хуулийн хугацаа хэтэрсэн 1371 хэрэг буюу 15.3 хувийг тус тусээлж байна.

Хүснэгт 10. Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл

№	Үзүүлэлт	Он		Өсөлт, бууралт	
		2020 он	2021 он	Тоо	Хувь
	<b>Тайлангийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7812</b>	<b>8947</b>	<b>1135</b>	<b>14.5</b>
1.	Хуулийн хугацаанд	5162	5397	235	4.6
2.	Хойшлуулсан	356	916	560	2.6 дахин
3.	Түдгэлзүүлсэн	1150	1263	113	9.8
4.	Хуулийн хугацаа хэтэрсэн	1144	1371	227	19.8

Анхан шатны шүүхийн иргэний хэргийн үлдэгдлийг 2020 онтой харьцуулбал 1135 хэргээр буюу 14.5 хувиар өссөн бөгөөд хуулийн хугацаанд байгаа хэрэг 4.6 хувиар, түдгэлзүүлсэн хэрэг 9.8 хувиар, хуулийн хугацаа хэтэрсэн хэрэг 19.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

<b>ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2021 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН /ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ/</b>	
<p>Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүд улсын хэмжээнд 2021 онд нийт 2875 хэрэг хүлээн авч, 2529 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс 1109 хэрэг буюу 43.9 хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 843 хэрэг буюу 33.3 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 577 хэрэг буюу 22.8 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 183 хэргийн үлдэгдэлтэй байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах нийт 16 хүсэлт гаргаснаас 13 хүсэлтийг хангахаас татгалзаж, 3 хүсэлтийг хангасан байна. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай 28 хүсэлтийг хянан шийдвэрлэснээс арбитрын 2 шийдвэрийг хүчингүй болгож, 26 шийдвэрийг хэвээр үлдээжээ.</p> <p>Нийт 38 хэрэгт давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 81 хэрэгт эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзаж буцаан авсан байна.</p> <p>Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2529 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 865 хэргээр буюу 25.5 хувиар буурчээ.</p>	

Хүснэгт 11. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэсэн байдал

№	Маргааны төрөл	Он		Өсөлт, бууралт	
		2020 он	2021 он	Тоо	Хувь
1.	Нийт хүлээн авсан хэрэг	3839	2875	-964	-25.1
2.	Нийт шийдвэрлэсэн хэрэг	3436	2573	-863	-25.1
3.	Хянан шийдвэрлэсэн хэрэг бүгд	3394	2529	-865	-25.5
4.	Давж заалдах гомдлыг хүлээж авах боломжгүй буюу үндэслэлгүй бол түүнийг хангахгүй орхиж, шийдвэрийг хэвээр үлдээсэн	1529	1109	-420	-27.5
5.	Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан	1167	843	-324	-27.8
6.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан бүгд	698	577	-121	-17.3
7.	Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	32	28	-4	-12.5

8.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	10	16	6	60.0
9.	Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан	76	38	-38	-50
10.	Давж заалдах гомдлоосоо татгалзсан	33	81	48	2.5 дахин
11.	Үлдэгдэл	294	183	-111	-37.8

**Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг:** Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 1819 хэрэг буюу 71.9 хувийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 103 хэрэг буюу 4.1 хувийг Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 84 хэрэг буюу 3.3 хувийг Баян-Өлгий аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 79 хэрэг буюу 3.1 хувийг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 82.7 хувийг эзэлсэн үзүүлэлттэй байна.

**Шийдвэрийн тогтвортой байдал:** Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлалын тоо 420 хэргээр буюу 27.5 хувиар, өөрчлөлт оруулсан магадлалын тоо 324 хэргээр буюу 27.8 хувиар, хүчингүй болгосон магадлалын тоо 121 хэргээр буюу 17.3 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

*Хүснэгт 12. Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал*

№	Хянан шийдвэрлэсэн байдал	Он		Өсөлт, бууралт		Эзлэх хувь		Зөрүү +,-
		2020 он	2021 он	Тоо	Хувь	2020 он	2021 он	
1.	Хэвээр үлдээсэн	1529	1109	-420	-27.5	45.1	43.9	-1.2
2.	Өөрчлөлт оруулсан	1167	843	-324	-27.8	34.4	33.3	-1.1
3.	Хүчингүй болгосон	698	577	-121	-17.3	22.8	22.8	2.2
	<b>Нийт дүн</b>	<b>3394</b>	<b>2529</b>	<b>-865</b>	<b>-25.5</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>-</b>

2020 онтой харьцуулбал анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ 1.2 хувиар, өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 1.1 хувиар тус тус буурсан бол хүчингүй болгосон магадлалын эзлэх хэмжээ 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Өөрчлөлт оруулсан:** 2021 онд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдлыг авч үзвэл шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн магадлал 706 буюу 83.7 хувь, шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон магадлал 137 хэрэг буюу 16.3 хувийг тус тус эзэлж байна.

Шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдлыг өнгөрсөн онтой харьцуулбал шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн магадлал 333 хэргээр буюу 32.1 хувиар буурч, шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон магадлал 9 хэргээр буюу 7 хувиар өссөн байна.



График 16. Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдал

**Хүчингүй болгосон:** Шүүхийн статистик мэдээнээс үзвэл “ИХШХШтХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 157 хэрэг 27.2 хувь, “шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлээр хүчингүй болсон 143 хэрэг буюу 24.8 хувь, “Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 91 хэрэг буюу 15.8 хувь, “хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” гэх үндэслэлээр 80 хэрэг буюу 13.9 хувь, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” гэх үндэслэлээр 73 хэрэг буюу 12.7 хувь, “ИХШХШтХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 26 хэрэг буюу 4.5 хувь “Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 5 хэрэг буюу 0.9 хувь, “Хуурамч нотлох баримтынүндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэлээр 2 хэрэг буюу 0.3 хувийг тус тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

Үүнээс гадна “Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл өмнөх оноос 140 хэргээр буюу 49.5 хувиар, “Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” үндэслэл өмнөх оноос 44 хэргээр буюу 35.5 хувиар, “ИХШХШтХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн” үндэслэл өмнөх оноос 9 хэргээр буюу 25.7 хувиар, “Хууль бус бүрэлдэхүүнээс хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 2020 оноос 4 хэргээр буюу 44.4 хувиар, “Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл өмнөх оноос 1 хэргээр буюу 33.3 хувиар тус тус буурсан байна. Харин “Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн” гэх үндэслэл өмнөх оноос 72 хэргээр буюу 4.8 хувиар, “ИХШХШтХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 2020 оноос 3 хэргээр буюу 1.9 хувиар, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн” үндэслэл өмнөх оноос 6 хэргээр буюу 9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 13. Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл

№	Анхан шатны шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	Он		Өсөлт, бууралт		Хүчингүй болсон хэрэгт эзлэх хувь		Зөрүү
		2020 он	2021 он	Тоо	Хувь	2020 он	2021 он	Тоо
1.	Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	283	143	-140	-49.5	40.5	24.8	-15.8

2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	19	91	72	378.9	2.7	15.8	13.0
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн	124	80	-44	-35.5	17.8	13.9	-3.9
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	9	5	-4	-44.4	1.3	0.9	-0.4
5.	Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	4	0	-4	-100.0	0.6	0.0	-0.6
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	3	2	-1	-33.3	0.4	0.3	-0.1
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн	154	157	3	1.9	22.1	27.2	5.1
8.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	67	73	6	9.0	9.6	12.7	3.1
9.	ИХШХШТХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн	35	26	-9	-25.7	5.0	4.5	-0.5
<b>Нийт дүн</b>		<b>698</b>	<b>577</b>	<b>-121</b>	<b>-17.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>0.0</b>

Давж заалдах шатны шүүх дэх иргэний хэргийн үлдэгдэл 183 хэрэг буюу өмнөх онтой харьцуулбал 111 хэргээр буюу 37.8 хувиар буурчээ. Хэргийн үлдэгдлээс Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 135 хэрэг буюу нийт үлдэгдлийн 73.8 хувийг эзэлсэн байна.

**ШЕЗ-ӨӨС ГАРГАСАН 2021 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТАЙЛАН  
/ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ/**

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 16 хэрэг дээр хяналтын шатны журмаар шинээр ирсэн 2661 хэрэг, ерөнхий шүүгчид гомдол гаргасан 63, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүсэлттэй 37 хэрэг, нийт 2777 хэрэг хүлээн авснаас, 1576 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 171 хэргийг хуралдаанд оруулахгүй шийдвэрлэж, 875 хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах 36 хүсэлтийг шийдвэрлэж, тайлант хугацааны эцэст 119 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар 1576 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 730 хэргээр буюу 86.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 14. Хяналтын шатны шүүхийн иргэний хэрэг*

№	Үзүүлэлт	Өсөлт, бууралт			
		2020 он	2021 он	Тоо	Хувь
1.	Хүлээн авсан нийт хэрэг	1120	2777	1657	2.5 дахин
2.	Хянан шийдвэрлэсэн хэрэг	1104	1783	679	61.5
3.	Хянаад хариу өгсөн хэрэг (Хуралдаанд оруулахгүй шийдвэрлэсэн)	182	171	-11	-6.0

4.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	76	36	-40	-52.6	
5.	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	846	1576	730	86.3	
6.	Үүнээс:	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон	479	916	437	91.2
7.		Шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан	188	356	168	89.4
8.		Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн	78	116	38	48.7
9.		Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон	18	22	4	22.2
10.		Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	19	34	15	78.9
11.		Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	64	132	68	2.1 дахин
12.	Хяналтын гомдол гаргасан хэргийг танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн хэрэг	-	875	875	-	
	<b>Үлдэгдэл</b>	<b>16</b>	<b>119</b>	<b>103</b>	<b>7.4 дахин</b>	

Хяналтын шатны шүүх нийт 1576 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон нь 916 хэрэг буюу 58.1 хувь, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан нь 356 хэрэг буюу 22.6 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн нь 116 хэрэг буюу 7.4 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон нь 22 хэрэг буюу 1.4 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь 34 хэрэг буюу 2.2 хувь, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 132 хэрэг буюу 8.4 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна.

2020 онтой харьцуулбал шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон 437 хэргээр буюу 91.2 хувиар, шийдвэр магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан хэрэг 168 хэргээр буюу 89.4 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн хэрэг 38 хэргээр буюу 48.7 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 4 хэргээр буюу 22.2 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 15 хэргээр буюу 78.9 хувиар, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэг 68 хэргээр буюу 2.1 дахин тус тус өссөн байна.

Хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиараа өмнөх оноос шийдвэр магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон хэрэг 1.5 хувиар, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан хэрэг 0.4 хувиар, шийдвэр магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэг 0.8 хувиар тус тус өссөн бол шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн хэрэг 1.9 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 0.7 хувиар, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 0.1 хувиар тустус буурсан байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 132 хэрэгт “Шүүх өөр хуулийг эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл 66 хэрэг буюу 50 хувийг, “ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж, хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 43 хэрэг буюу 32.6 хувийг, Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан” үндэслэл 16 хэрэг буюу 12.1

хувийг, “Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн” үндэслэл 4 хэрэг буюу 3 хувийг, “Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн” үндэслэл 3 хэрэг буюу 2.3 хувийг тус тус эзэлсэн байна.

Тайлант хугацааны эцэст 119 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 103 хэргээрэссэн байна. Үүнээс хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэрэг байхгүй байна.

*Хүснэгт 15.Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл*

№	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл	Он		Өсөлт, бууралт	
		2020 он	2021 он	Тоо	Хувь
1.	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	26	66	40	2.5 дахин
2.	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	0	4	4	-
3.	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсэн	5	3	-2	-40.0
4.	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	0	0	0	-
5.	Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	16	16	-
6.	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	0	0	0	-
7.	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн	33	43	10	30.3
	<b>Нийт</b>	<b>64</b>	<b>132</b>	<b>68</b>	<b>2.1 дахин</b>

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Хяналтын шатны шүүхийн чиг үүрэг, эрх хэмжээ” сэдэвт энэхүү судалгааны ажлын хүрээнд УДШ-ийн бүрэн эрх, эрх хэмжээ, чиг үүргийн талаар бусад гадаад улсын шүүхийн тогтолцоо, хуулийн зохицуулалтад харьцуулсан судалгаа хийхийн зэрэгцээ дотоодын эрх зүйн эх сурвалжийн хүрээнд түүхчилсэн судалгаа хийсэн. УДШ-ийн чиг үүрэг, эрх мэдлээ хэрэгжүүлэх хүрээг Монгол Улсын ИХШХШтХ, МУШтХ-ийн хөгжилд тулгуурлан судалж хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, түүнд тавигдах хязгаарлалт зэрэг асуудлын хүрээнд ИХШХШтХ-ийн зохицуулалтын хөгжил болон бусад гадаад улсын туршлагад үндэслэн судаллаа.

Ихэнх гадаад улсын шүүхийн системд хийсэн судалгааны хүрээнд УДШ буюу хяналтын шатны шүүх нь “шүүх эрх мэдлийн дээд байгууллага” болохын хувьд хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг Үндсэн хуульдаа тусгаж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хянах чиг үүрэг, бүрэн эрхтэй байгууллага байхаар зохицуулсан байдал ажиглагдлаа. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсад өмнө нь батлагдаж байсан он оны ИХШХШтХ болон МУШтХ-ийн зохицуулалтад агуулгын хүрээнд тусгагдаж байжээ.

2021 онд Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсан нь шүүхийн системд өөрчлөлт, шинэчлэл хийсэн ихээхэн том алхам болсон билээ. Тус хуулийн зохицуулалтад дурдсан агуулгаар тайлбарлавал Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүхийн үндсэн чиг үүрэг нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах буюу энэ зорилгын хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг тодорхой хүрээнд хуульд заасан үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд хянахаар болж өөрчлөгдсөн. Энэ нь БНСУ, ОХУ болон Франц Улсын эрх зүйн зохицуулалтад УДШ-ийн буюу хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, чиг үүргийн талаар зохицуулсан зохицуулалтын агуулгатай адил төсөөтэй болно.

Хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй этгээдийн хувьд өмнөх оны ИХШХШтХ-д харьцангуй хязгаарлагдмал этгээдэд эрх олгон хуульчилсан байсан бол 1994 болоод 2002 оны ИХШХШтХ-ийн зохицуулалтад тусгаснаар УДШ-д хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй этгээдүүдийн хүрээ улам өргөжин тэлсэн, энэ нь ОХУ-ын мөн харилцааг зохицуулсан зохицуулалтын агуулгатай ижил төсөөтэй, иргэний Монгол Улсын Үндсэн хуульд заасан “...шүүхийн шийдвэрийг давж заалдах...”<sup>21</sup> эрхийн баталгааг хангасан зохицуулалт болсон байна.

УДШ-д хяналтын журмаар гомдол гаргах тухай ИХШХШтХ-ийн зохицуулалтад оруулсан 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр оруулсан өөрчлөлт нь дэлхийн өндөр хөгжилтэй орны шүүхийн тогтолцоонд хяналтын шатны шүүхийн эзлэх байр суурь, үүрэг оролцоотой (судалгааны хүрээнд авч үзсэн Франц Улс нь 2021 оны байдлаар эрх зүйт ёсны индексээрээ дэлхийд 23 дугаар байрт жагсаж байгаа, ОХУ мөн үүнд багтана) буюу тодруулбал, хяналтын шатны шүүх нь шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг хангах, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх талаар практик төлөвшүүлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэхийг хянадаг гэдэг агуулгатай дүйх зохицуулалтыг хуульчилсан нь сайшаалтай болжээ гэж үзсэн.

Харьцуулсан судалгааны хүрээнд дурдсан БНХАУ, БНСУ нь тус бүрдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон УДШ-ийн эрх хэмжээ, чиг үүргийг зохицуулсан зохицуулалтын хувьд Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахад харьцангуй ялгаатай байна. БНХАУ-ын улсын хэмжээнд ихээхэн нөлөө үзүүлсэн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг онцлог бүхий зохицуулалттай байсан бол БНСУ-н онцлог зохицуулалт нь МУШтХ-д 2021 онд тусгагдсан, ИХШХШтХ-д оруулсан хяналтын журмаар

<sup>21</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг.

гомдол гаргахтай холбогдон орсон өөрчлөлттэй зарим талаараа адил буюу жишээ нь “Шүүх хуулийг УДШ-ийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлан хэрэглэсэн тохиолдолд”, “шүүхээс хуулийг тайлбарласан нь үндэслэлгүй буюу шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй бол” хяналтын журмаар гомдол гарган хянан шийдвэрлүүлэх боломжтой байсанд оршино. ОХУ-ын эрх зүйн холбогдох зохицуулалтын хувьд Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалттай харьцангуй төсөөтэй байна. Жишээлбэл: ОХУ-ын Шүүхийн тогтолцооны тухай хуульд Оросын Холбооны Дээд шүүх нь шүүх эрх мэдлийн дээд байгууллага байна, тус шүүхээс хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд албан ёсны тайлбар гаргах эрхтэй зэргээр хуульчилжээ. Түүнчлэн ОХУ нь иргэнлэг эрх зүйн тогтолцоотой улсын нэгд зүй ёсоор тооцогдох тул ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульдаа хяналтын журмаар гомдол гаргах тухай зохицуулсан. Ингэхдээ прокурор хяналтын журмаар эсэргүүцэл бичихээр /гомдол гаргахаар/ зохицуулсан нь онцлог байхын зэрэгцээ Оросын Холбооны Дээд шүүхэд хууль тайлбарлах эрх олгон зохицуулсан нь Монгол Улсын хуулийн зохицуулалттай адил төстэй байна.

Тоон мэдээллийн хүрээнд УДШ-ийн Практик судлалын хэлтсээс ШССМХ-д ирүүлсэн статистик мэдээлэл, ШЕЗ-өөс гаргасан Монгол Улсын шүүхийн тайлан, шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн судалсан болно. МУШТХ 2021 онд батлагдан 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн. Иймд ИХШХШТХ-д заасан хяналтын гомдол гаргах үндэслэл өөрчлөгдөөгүй байсан үе буюу 2020 он, ИХШХШТХ-д заасан хяналтын гомдол гаргах үндэслэл өөрчлөгдсөн, МУШТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдан хэрэгжиж эхэлсэн үе буюу 2021 оны Монгол Улсын шүүхийн тайланд дурдсан дэлгэрэнгүй тоон мэдээг бэлтгэлээ. Тус тайлангаас харвал иргэний хэргийн анхан шатны шүүх нийт Монгол Улсын хэмжээнд 2020 онд 53 мянга гаруй хэрэг хянан шийдвэрлэсэн бол 2021 онд энэ тоо 45 мянга болон буурсан байна. УДШ-ийн хянан шийдвэрлэсэн нийт маргааны тоо 2020 онд 1100 орчим байсан бол 2021 онд 1800 орчим болж өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд УДШ-ийн хянан шийдвэрлэсэн ихэнх маргаанд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхиж байсан бол энэ тооны харьцаа 2021 онд ч мөн адил төстэй байна.

2020 оны Монгол Улсын шүүхийн тайлангаас харахад нийт 1104 хэргийг хянан шийдвэрлэхдээ түүнээс 182-ыг хянаад хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэсэн, шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй 26 маргаан, ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн 33 маргаан байсан. 2021 оны тайланд дурдсанаар нийт 1783 хэргийг хянан шийдвэрлэхдээ түүнээс 171-ийг хянаад хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэсэн, шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй 66 маргаан байсан бол ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн 43 маргаан байсан гэж судлагдсан нь 2020 онтой харьцуулахад өссөн үзүүлэлт болжээ.

